



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/696

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын бэлтгэл хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам, Засаг даргын Тамгын газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажилласан Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Батзоригийн гаргасан хүсэлтийн дагуу орон сууцны зээлийн хөнгөлөлтөд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 12,812,900 (арван хоёр сая найман зуун арван хоёр мянга есөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргаж шийдвэрлэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Н.Наранцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Хулан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

